



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Мега төслүүдийг эрчимжүүлж,
бүтээн байгуулалтыг дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг “Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого болон хөгжлийн бодлого, үзэл баримтлалд суурилсан, эдийн засгийн өсөлтийг хангасан, байгаль орчинд ээлтэй, аюулгүй, найдвартай тээврийн дэд бүтцийг хөгжүүлж, салбарын бүтээн байгуулалт, мега төслүүдийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

Нэг.Зам, тээврийн салбарт 2025 оныг “Мега төслүүдийг эрчимжүүлж, бүтээн байгуулалтыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн яам болон харьяа байгууллага, салбарын төрийн өмчийн компаниудын дарга, захирал, удирдлагад дараах арга хэмжээг хэрэгжүүлж, эрчимжүүлж ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

1.1.Төмөр зам, далайн тээврийн салбарт:

1.1.1.Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн дамнасан төмөр замын барилгын ажлыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх;

1.1.2.Ханги-Мандал боомтыг “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмж тусгах;

1.1.3.Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замын барилгын ажлыг 2025 онд багтаан эхлүүлэх;

1.1.4.Багахангай-Хөшигийн хөндийн чиглэлийн салбар төмөр зам төслийг 2025 оны 2 дугаар хагаст хэрэгжүүлж дуусгах;

1.1.5.Хөшгийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах байршлыг нарийвчлан тогтоон газрын асуудлыг 2025 онд багтаан шийдвэрлүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд терминал байгуулах ажлыг эхлүүлэх, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй тээвэр логистикийн терминалуудыг шат дараалалтай шилжүүлэх;

000000001

1.1.6. Их багтаамжийн нийтийн тээврийн Хөнгөн төмөр замын тээвэр (LRT) төслийн Техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу, чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэн 2025 оны 3 дугаар улиралд багтаан хүлээн авах;

1.1.7. “Замын-Үүд бүс нутгийн логистик”-ийн төвийг түшиглэн хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэх. Экспорт, импортын барааны тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах.

1.2. Иргэний нисэхийн салбарт:

1.2.1. Олон улсын дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн барилгыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан байнгын ашиглалтад оруулах;

1.2.2. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын өргөтгөл, нислэгийн хөдөлгөөний удирдлагын нөөц төв байгуулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

1.2.3. Транзит зорчигч урсгалыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Чингис хаан” олон улсын нисэх буудалд зочид буудал байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, 2 дугаар улиралд багтаан барилгын ажлыг эхлүүлэх;

1.2.4. “Дэлүүн болдог” Өндөрхаан нисэх буудлын барилга угсралтын ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан байнгын ашиглалтад оруулах;

1.2.5. Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын хөөрч, буух зурвас засварын ажлыг 2025 оны 6 дугаар сард багтаан дуусгаж, нисэх буудал байгуулах байршлыг тодорхойлж, хүчин чадлыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах;

1.2.6. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд шууд нислэг хийх бэлтгэл ажлыг ханган эхлүүлэх.


1.3. Авто замын салбарт:

1.3.1. Бүсүүдийн хөгжлийг дэмжих хүрээнд олон улсын авто замын шинэ коридор байгуулах, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эрчимжүүлэх;

1.3.2. Хавирга хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох;

1.3.3. Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэх;

1.3.4. Замын-Үүд-Хөшгийн хөндий чиглэлийн тусгай зориулалтын авто замыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих төслийг 3 дугаар улиралд багтаан эхлүүлэх;



1.3.5."Хөшгийн хөндийн туннел", "Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу, чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэн 2025 оны 2 дугаар улиралд багтаан хүлээн авах;

1.3.6.Зам барилгын ажлуудыг график хугацааны дагуу эхлүүлж, үргэлжлүүлэх, дуусгах ажлыг шуурхай, чанартай зохион байгуулах.

1.4.Авто тээврийн салбарт:

1.4.1.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын зорчигч тээврийн авто буудлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, барилга угсралтын ажлыг эхлүүлэх;

1.4.2.Ховд аймгийн зорчигч тээврийн авто буудлын барилгын ажлыг дуусган ашиглалтад оруулах;

1.4.3.Агаар орчны бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, замын хөдөлгөөнд оролцож буй авто тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, автомашинаас ялгарч буй утаанд тавих стандартын шаардлагыг хангуулах, зориулалтын нүүрсэн яндангүй (катализаторгүй) автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

1.5.Улаанбаатар метро төсөл, Дүүжин замын тээвэр төсөл, Трамвайн төсөл, зэрэг олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн стандарт, норм нормативыг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.


1.6.Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах чиглэлээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр даалгасан арга хэмжээг эрчимжүүлэх.

1.7.Бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлох, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэн, бүтээн байгуулалтыг эрчимжүүлж ажиллах.

1.8.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн стандарт, шинэ техник технологи, инновацын шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

1.9.Зам, тээврийн салбараас шалтгаалсан агаар орчны бохирдлыг болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх.


1.10.Зам, тээврийн салбарын дэд бүтэц, үйл ажиллагааны ашиглалт, засвар үйлчилгээ, техник технологийн хяналт, аюулгүй ажиллагааг хангахад анхаарч, бүх талын арга хэмжээг шуурхай авч ажиллах.



1.11."Мега төслүүдийг эрчимжүүлж, бүтээн байгуулалтыг дэмжих жил"-ийн хүрээнд ажлын төлөвлөгөөг сар бүрээр нарийвчлан төлөвлөн, батлуулж, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг улирал бүрээр тайлагнах.

1.12.Зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр мэдээлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулах.

Хоёр.Албан даалгаварын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн танилцуулахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Батболд)-д даалгасугай.

САЙД  Б.ДЭЛГЭРСАЙХАН

